

**МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН АЛБАН ТУШААЛААС ЧӨЛӨӨЛӨХ
ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2019 оны 11 дүгээр
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын дарга Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 4 дэх заалтыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч Надмидын Баяртсайханыг Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлүүлэх саналаа Улсын Их Хуралд 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр гаргасан байна.

Эдийн засгийн байнгын хороо 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар Н.Баяртсайханыг Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх уг саналыг дэмжлээ.


Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36¹ дүгээр зүйлийн 36^{1.1} дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хурлын даргын саналын хамт Та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Надмидын Баяртсайханыг Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай асуудлаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ж.ГАНБААТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

**Монголбанкны Ерөнхийлөгчийн албан
тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Надмидын Баяртсайханыг Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: secretariat@parliament.mn
http://www.parliament.mn

2019. 11. 05 № 1/11927
танай _____-ны № _____-т


Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монголбанкны Ерөнхийлөгч Надмидын Баяртсайхан нь тус албан тушаалд ажиллах хугацаандаа улсын эдийн засгийг тогтворжуулж, санхүүгийн орчныг эрүүлжүүлэх чиглэлээр гадаадад болон дотооддоо итгэл хүлээлгэхүйц орчин нөхцөлийг бүрдүүлэх, мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах олон улсын байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрээгүй, түүнчлэн 2019 оны 6 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Монголбанкны 2018 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцээд хангалттай биш гэж үзэж Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Иймд Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 4 дэх заалтыг үндэслэн Н.Баяртсайханыг Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх саналыг оруулж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

ДАРГА



Г.ЗАНДАНШАТАР

ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ ХУУЛИАС

26 дугаар зүйл. Монголбанкны удирдлага

1. Монголбанкийг Улсын Их Хурлаас томилогдсон Ерөнхийлөгч толгойлж үйл ажиллагаагаа Улсын Их Хурлын өмнө хариуцан тайлагнана. **Монголбанкны Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын даргын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.**

2. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нарыг Монголбанкны Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.

3. Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг томилохдоо түүний эдийн засаг, банк, санхүү, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвар, мэргэжлийн ёс зүй, ажлын туршлагыг харгалзана.

6. **Улсын Их Хурал Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг дор дурдсан тохиолдолд албан тушаалаас нь чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ:**

- 1/ арилжааны банкны хувьцаа эзэмшигч болсон;
- 2/ Монголбанкны эрх ашигт харш үйлдэл /эс үйлдэл/ гаргасан;
- 3/ биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй гэж үзэж, уг албан тушаалаас чөлөөлж өгөхийг хүссэн;
- 4/ **үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн;**
- 5/ гэмт хэрэг үйлдсэнийг нь шүүх тогтоосон;
- 6/ ашиг сонирхлын бусад зөрчил үүссэн.

7. Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нар үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш нэг жилийн дотор банкны удирдах албан тушаалд ажиллахыг хориглоно.

8. **Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа тэдгээрийг томилсон өдрөөс эхэлж, Улсын Их Хурлаас дараагийн Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг томилсноор дуусгавар болно.**

Лавлагаа гаргасан: Эдийн засгийн байнгын хорооны ажлын алба